



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/193

Мандалговь

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 6 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ковид-19 цар тахал Монгол улсад бүртгэгдэж өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, хөл хорио тогтоосон онцгой байдлын үед ажилласан эрүүл мэндийн салбарын зарим албан хаагчдад урамшуулал олгосугай.

2. Урамшуулал олгох албан хаагчдын нэрс, зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Зардалд шаардагдах 10.000,000 (Арван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Цаашид Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад хамрагдаж байгаа төрийн албан хаагчдын илүү цагийн хөлсийг цаашид тухайн байгууллага, аж ахуйн нэгж батлагдсан төсөвтөө багтаан хариуцан ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210343